



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/89.

Мандалговь

“Ашид бьулдинг” ХХК-тай гэрээ байгуулах
тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”- 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн А/49 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих Цэцэрлэгийн барилгын дээврийн засвар (Дундговь, Сайнцагаан сум, 5 дугаар цэцэрлэг) ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Ашид бьулдинг” ХХК-тай 18,966,085 (арван найман сая есөн зуун жаран зургаан мянга наян тав) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг, төсвийн дагуу 5-р Цэцэрлэгийн барилгын дээврийн засварын ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Ашид бьулдинг” ХХК-ны гүйцэтгэх захирал (О.Мөнхсаруул)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), 5-р цэцэрлэгийн эрхлэгч (Л.Дэлгэрмаа), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060362